

**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН  
САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН  
2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026  
ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ  
ХИЙСЭН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 10 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 09 дүгээр сарын 15, 18, 19, 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд "Улсын Их Хурал төсвийн төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн үед олон нийтийн хэлэлцүүлэг хийж болно" гэж заасны дагуу Төсвийн байнгын хорооноос "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж, эрсдэл", "Боловсролын салбарын 2026 оны төсөв", "Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүд", "Төсвийн орлого бүрдүүлэлт", "Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын 2026 оны төсөв", "Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын 2026 оны төсөв" гэсэн 6 сэдвийн хүрээнд олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Дээрх хэлэлцүүлэгт иргэд, иргэний нийгмийн байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газар, Сангийн яам болон төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн бус байгууллагуудаас давхардсан тоогоор танхимаар 394, цахимаар 17 төлөөлөл оролцсон бөгөөд хэлэлцүүлгийн зарыг Улсын Их Хурлын албан ёсны вэб хуудас [www.parliament.mn](http://www.parliament.mn), цахим хуудас [Parliament.mn](http://Parliament.mn) хаягуудад байршуулж, олон нийтийн оролцоог ханган ажилласан болно.

Хэлэлцүүлэгт оролцогчдоос эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлэх, багш, эмчийн цалин, ахмад настны тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг урт хугацааны хөгжлийн бодлогын зорилттой уялдуулах, гадаад зээл, тусламжийн ашиглалт, түүний үр дүнг үнэлж, өрийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх, татварын шинэчлэлээр иргэд, аж ахуйн нэгжүүдийн татварын дэмжлэгийг оновчтой болгож өрхийн орлогыг дэмжихэд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 29, 30, 10 дугаар сарын 01, 07-ны өдрүүдийн хуралдаанаараа

хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, танилцуулгаа боловсруулан Төсвийн байнгын хороонд ирүүлснийг Та бүхэнд танилцуулж байна.

### **1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгын талаар:**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан Батлан хамгаалахын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох зохицуулалттай нийцэхгүй байгааг анхаарах, нууцад хамаарах төсөл, хөтөлбөрөөс бусад нийгмийн шинжтэй арга хэмжээний задаргааг төсөлд тусгах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Бум-Очир, Ц.Мөнхбат нар гадаад улсад суугаа Элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газруудын барилга, урсгал засварын зардал, “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-гийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Н.Наранбаатар, Ө.Шижир, Ц.Мөнхбат, Б.Тулга, Н.Батсүмбэрэл нар онцгой байдлын салбар, ялангуяа орон нутагт онцгой байдлын шинэ анги, салбарыг ажиллуулах, шаардлагатай дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмж, машин механизм, зориулалтын хувцас, хэрэгслээр хангахад шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгасан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ц.Мөнхбат нар орон нутаг дахь зэвсэгт хүчний анги, салбарууд, тусгай сургалт, бэлтгэлийн төвийн барилгын засвар болон албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах хөрөнгийг төсвийн төсөлд тусгасан эсэх, улсын төсвөөс санхүүжилт авдаггүй аймаг, сумд хөрөнгө мөнгөний хүрэлцээгүй байдал үүсгэж байгааг хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Батлан хамгаалах яам, Онцгой байдлын ерөнхий газар, Гадаад харилцааны яамны батлагдсан төсвийн зарцуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжиж байгаа бөгөөд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын төсвийн талаар, мөн Үндэсний батлан хамгаалахын их сургуулийг чадавхжуулахаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авсан байна.

Дээрх хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд дэлхий нийтийн тогтворгүй нөхцөл байдлаас үүдэн батлан хамгаалах салбар, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, гал, ус, зуд зэрэг байгалийн гамшгийн үед батлан хамгаалах, онцгой байдлын салбар бэлэн байх, мөн иргэдийг чадавхжуулан сургахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа гадаад харилцааны салбар болон батлан хамгаалах салбарын ажиллагсдын цалин хангамж, ажиллаж амьдрах нөхцөлийг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртгүүд нэмэгдэж байгаад анхаарч, шалтгааныг тодруулах нь зүйтэй бөгөөд 2026 оны төсвийг үр дүнтэй захиран зарцуулах талаар санал хэлсэн байна.

### **2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгын талаар:**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Бейсен нар хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа урамшууллын дүн ирэх онд өөрчлөгдсөн эсэх, тус салбарт хэрэгжүүлж байгаа аяны хүрээнд олгох зээл, зээлийн хүүгийн зөрүүнд төсөвлөсөн хөрөнгийн талаар, мөн зэрлэг амьтны өвс, тэжээлийн зардал, улаанбуудайн нөөц бүрдүүлэлтийн талаар болон малын тэжээлийн хангамжийн асуудалд тухайлсан бодлого, зохицуулалт хийж байгаа эсэх, биологийн олон янз байдлын хамгааллын менежментийг байгаль цаг уурын нөхцөлтэй уялдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Л.Мөнхбаясгалан, Ц.Туваан нар байгаль орчны салбарт төсөвлөсөн 181.0 тэрбум төгрөгийн зарцуулалтад говийн бүсийн газрын доорх усны нөөцийг хамгаалах, менежментийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах, Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах хоолой барих төслүүдийг хэрэгжүүлэх зардлыг тооцсон эсэх, гангийн гамшгаас шалтгаалан тариалангийн салбарт бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах болон олгох урамшууллын зардал төсөвт туссан эсэх, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг байгаль хамгаалагчдын зардал, "Зарим газрыг тусгай хамгаалалтад авах тухай" Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тухайн газрын нөхөн олговрын талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай өвөлжилтийн бэлтгэл, өвс тэжээлийн үнийн өсөлт, хадлан тэжээл бэлтгэх, бэлчээрийн доройтол, хөрсний бохирдол зэрэг тулгамдаж байгаа асуудлыг эрэмбэлэн холбогдох зардлыг төсөвт туссан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Ц.Идэрбат нар хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд олгож байгаа зээлийн ашиглалтыг сайжруулах, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор агаар, хөрс орчны бохирдлыг бууруулах болон цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээний зардлыг улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд ашиглаж байгаа тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт үзүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодруулж, хувийн хэвшлээр хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг улсын төсөвт тусган санхүүжүүлэх шаардлагагүй гэсэн саналуудыг хэлсэн байна.

### **3.Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгын талаар:**

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл "Шинэ хоршоо" хөтөлбөрийн үйл ажиллагаа, санхүүжилт, үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, А.Ариунзаяа нар төрийн албан хаагчдыг өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог 36 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг хувааж олгохоор төсөлд тусгасан нь холбогдох хуулиудыг зөрчиж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалт, техник хэрэгслийн хангалт, ажиллагсдын орон тооны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат төрийн албан хаагчдыг цомхотгох бодлогын хэрэгжилт, шинжлэх ухааны академийн байгууллагын харьяаллын талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийн талаар асуулт асууж, тодруулсан байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, М.Бадамсүрэн нар төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь улсын хөгжлийн жилийн

төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар шинжлэх ухааны салбарын болон төрийн албан хаагчдын сургалт хөгжлийн төсвийн хүрэлцээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир сонгуулийн цахим системийг шинэчлэхэд шаардагдах төсөв, Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад харилцааны төсөв болон Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн төсвийн харьяаллын талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан 2026 оны төсвийн төсөлд төрийн албан хаагчдад өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог 36 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийг он дамжуулан олгохоор тусгасан нь холбогдох хуульд нийцэж байгаа эсэх талаар Улсын Их Хурлын Тамгын газраар хууль зүйн зөвлөмж гаргуулах горимын саналаар санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, О.Саранчулуун, М.Бадамсүрэн, Э.Болормаа нар төсвийн бодлогыг эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудлуудад чиглүүлэх, тухайн жилийн төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах процессыг шинэчлэх, төрийн албаны шалгалтын агуулгад хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудлыг тусгах, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаарх саналуудыг хэлсэн.

#### **4.Хууль зүйн байнгын хорооны танилцуулгын талаар:**

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд, Ц.Сандаг-Очир, Даваагийн Цогтбаатар нар шинэ хөрөнгө оруулалтын эрэмбэлэлт, он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний санхүүжилтийн талаар, мөн Хүний эрхийн Үндэсний комиссын төсөв буурсан шалтгаан, Хүүхэд, гэр бүлийн дагнасан шүүхийн төсвийн талаар болон хууль хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хасагдаж батлагдсан тохиолдолд үүсэх үр нөлөөг судалсан эсэх, тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас ирэх оны төсвийн талаар санал, хүсэлт Байнгын хороонд ирүүлсэн эсэх, төрийн албан хаагчдыг 9 хувиар цомхотгох бодлого нь байгууллагуудын төсөв, ажлын бүтээмж, үр дүнтэй хэрхэн уялдаж байгаа талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир, Л.Мөнхбаатар, Дамдины Цогтбаатар нар иргэдийн амар тайван, аюулгүй байдлын төлөө үйл ажиллагаа явуулдаг хууль зүйн салбарын байгууллагуудын төсвийг бусад салбартай адилтган нийтлэг байдлаар бууруулах нь тохиромжгүй бөгөөд тухайн салбарын байгууллагуудын орон тоо дутуу байгааг анхаарч ажиллах орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай талаар, мөн донтолттой тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх төсвийг анхаарах, Засгийн газар төрийн албан хаагчдын ажлын байрны чиг үүргийн шинжилгээг нэгдсэн бодлогоор хийх, хууль зүйн салбарын үйл ажиллагааны хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Хүний эрхийн Үндэсний комиссын оролцоог хангах талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах шийдвэр нь салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул дахин хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн байна.

#### **5.Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгын талаар:**

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Б.Найдалаа, Г.Лувсанжамц, С.Цэнгүүн, Ө.Шижир, О.Батнайрамдал, Х.Булгантуяа, Г.Очирбат, Э.Одбаяр, Ц.Баатархүү нар 14 мега төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төсвийн орлого нэмэгдүүлэх боломжийн талаар болон мөн гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа төсвийн хөрөнгө оруулалт, орон сууцжуулах ажлын явц, ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт хамруулахад шаардагдах төсөв, тооцооллын талаар асуулт асууж, холбогдох хариултыг авсан байна.

Тус хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн Засгийн газар төсөв, эдийн засгийн бодлогыг боловсруулахад шаардлагатай санал, тулгамдаж байгаа асуудлуудыг тухай бүр холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлдэг байх, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир төсвийн урсгал зардал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн боловч багш, эмч нарын цалин, ахмадуудын тэтгэврийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ аваагүй байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа төсвийн төслийг боловсруулахдаа зарчмын өөрчлөлт хийж, хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц төсвийн төслийн шалгуур үзүүлэлтийг бодитой төлөвлөж, батлах нь төсвийн зарцуулалтыг үр дүнтэй болгож иргэд, хувийн хэвшлийн асуудлуудыг шийдвэрлэдэг төсвийг боловсруулж батлахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Оюу толгой төслөөс хүртэх үр ашиг, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат мега төслүүдийг эрчимжүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн орлогыг нэмэгдүүлэх болон биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж 2026 оны төсөвт говийн бүсийг усжуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах хөрөнгийг тусгах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан байна.

#### **6.Өргөдлийн байнгын хорооны танилцуулгын талаар:**

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төсвийн урсгал зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байх хязгаарыг өөрчлөн боловсрол, эрүүл мэндийн салбарын санхүүжилт, ахмадын тэтгэврийг нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц улсын хөгжлийн төлөвлөгөө болон төсвийн төслийн шалгуур үзүүлэлтүүд хоорондоо уялдахгүй байгааг анхаарч, цаашид шалгуур үзүүлэлтийн шаардлага хангагдаагүй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхгүй байх, мөн төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийг бүтэн олгоход шаардагдах хөрөнгийг 2026 оны төсөвт бүрэн тусгах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлгээний ямар аргачлалаар эрэмбэлж байгаа болон олон улсад хэрэглэгддэг аргачлалуудыг ашигладаг эсэх, Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн хөрөнгө оруулалтын саналыг эрэмбэлэхдээ богино хугацаанд эргэн төлөгдөх, төсөвт өртөг нь 5.0 тэрбумаас бага үнийн дүнтэй хөрөнгө оруулалтыг бүрэн тусгах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт нь иргэдийн амьдралд хүндээр тусаж байгаа тул инфляцыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, улсын

хөгжлийн төлөвлөгөөг батлахдаа төрийн өмчит компаниудын зардлыг 15.0 хувиар бууруулж, бүтээмжийг 30.0 хувьд хүргэх шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийн талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа Засгийн газраас 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарласан боловч Боловсролын сайдын төсвийг 1.0 их наяд төгрөгөөр бууруулахаар төсвийн төсөлд тусгасан нь 300.0 мянган хүүхдийн эрх зөрчигдөж, 16.0 мянган багш, ажилчдын цалин хөлс буурч байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат инфляцыг жил бүр хамгийн багаар төлөвлөдөг тул бодит байдал дээр иргэдийн худалдан авах чадвар нь буурч байгааг анхаарах, хөрөнгө оруулалтыг зөв эрэмбэлэх, төрийн албан хаагчдыг тэтгэвэрт гарахад нь олгодог 36 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг төсөвт бүрэн тусгах, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, иргэд эрүүл мэндийн даатгалаараа эмнэлгийн үйлчилгээ бүрэн авч чадахгүй байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл 2026 онд хэрэгжиж дуусах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, улсын төсвийн урсгал зардлыг 24 хувиар хязгаарласныг нэмэгдүүлэх боломжийг судлах, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн суурь салбаруудыг санхүүжүүлэхэд Сангийн яам анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

#### **7.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгын талаар:**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал мэдээлэл, технологийн үйлчилгээ болон мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зардлын өсөлт, хувийн өмчийн сургуулиудад улсын төсвөөс олгох санхүүжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат ирэх оны төсөвт эрүүл мэндийн салбарын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгө тусгагдсан эсэх, иргэдийн ипотекийн зээлд хамрагдалтын талаар, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар, багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэх чиглэлээр салбарын яамдын хэрэгжүүлж байгаа бодлого, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын биеийн тамирын арга хэмжээнд зориулсан зардал төсөвт тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа эмч, багш нарын цалинг урт хугацаанд ямар бодлого хэрэгжүүлж, хэрхэн нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжилд чиглэсэн зардлын ангиллыг үүсгэх боломжтой эсэх, энэ хүрээнд яамд холбогдох төсвийг тусгаж Сангийн яаманд ирүүлсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Монгол Улсын Засгийн газраас 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгосонтой холбогдуулан хөдөө, орон нутагт шаардлагатай сургууль, цэцэрлэгийн барилгын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, орон нутагт мэргэжлийн багш дутагдалтай эсэх талаар асуулт асууж, холбогдох хариултыг авсан байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар боловсролын салбарт хэрэгжиж буй гүйцэтгэлийн үнэлгээ нь боловсролын чанарыг нэмэгдүүлэх, багшийн хөгжлийг хангах чиглэлд нөлөөлсөн эсэх, боловсролын салбарт хэрэгжүүлэх санхүүгийн түрээсийн үйлчилгээний талаар, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын биеийн тамирын заал, Баяннуур сумын дотуур байрны барилгын санхүүжилт, төсөвт тусгагдсан эсэх болон ахлах ангийн сурагчдад зориулсан цахим сургалтын зардлыг нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү тэтгэврийн тогтолцооны

тогтолцооны суурь шинэчлэлийг хийх боломжтой эсэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн уялдаа холбоо, сангуудын төсвийн зарцуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах ахлах сургуулиудыг төрөлжүүлэн хөгжүүлэх, бүс нутгуудад "Коосен" хөтөлбөр бүхий сургууль байгуулах зорилтод чиглэсэн төсөв хөрөнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир багш нар гүйцэтгэлийн үнэлгээний нэмэгдлээ авч байгаа эсэх, мөн соёлын өвийг хамгаалах бодлогын талаар, Засгийн газраас бонд гаргаж эмч, багш нарын цалинг нэмэгдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлж буй соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын төсвийг хассан талаар, тус салбарын төсвийг бууруулсныг нэмэгдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг 2026 онд ахмадуудын эрүүл мэнд, соёл спорт, насан туршийн боловсролд зориулсан арга хэмжээний зардал болон боловсролыг дэмжих жилийн хүрээнд хийгдэх ажил, хүрэх үр дүн, Боловсролын зээлийн сангийн санхүүжилт, зээлийн эргэн төлөлтийн талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа хүний хөгжлийн чиглэлд төсвийг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар цахим сургалтыг хөгжүүлэх, Боловсролын яамны бүтцэд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын газрыг байгуулах, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат боловсрол, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа Засгийн газрын түвшинд төсөл, хөтөлбөрүүдийг эрэмбэлж төсөвт тусгах, салбар хоорондын уялдааг хангаж хүний хөгжлийг дэмжихэд анхаарч ажиллах гэсэн саналуудыг гаргасан байна.

Төсвийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Хуулийн төслийг байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр 2026 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын хавсралтад тусгагдсан Хавдар судлалын үндэсний төвийн II цогцолборын барилга, гадна шугам сүлжээний ажил болон зураг төсөл, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан төсвийн төсөлд багш нарын цалинг нэмж тусгах боломжтой эсэх, ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт хэдэн төгрөг төсөвлөсөн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон амьжиргааны доод түвшнээс доогуур байгааг анхаарч, тэтгэмжийг нэмэгдүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин 2026 оны төсвийн төсөлд шинээр тусгагдсан тоног, төхөөрөмжийн зардлын 63 багцын салбарын хуваарилалт болон боловсрол, эрүүл мэндийн салбарт ногдох хувь хэмжээний талаар мөн Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нэмэгдүүлэх тооцооллын үндэслэл, Эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн сангийн бүрдүүлэлт хуульд заасан хэмжээнд хүрээгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа төсвийн төслийг боловсруулахдаа уул уурхайн бүтээгдэхүүний орлогод тулгуурлан зардлыг тооцож байгаа талаар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны шүүхийн шийдвэрийн өрийг нэмэгдүүлсэн үндэслэл, Багануур, Шивээ-Овоо ХК-ийн өрийг улсын төсөвт тусгасан эсэх талаар асуулт асууж, тодруулга авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлаж, цалин хөлс, тэтгэвэр, урсгал зардлын зохицуулалт болон 80-аас дээш хувийн гүйцэтгэлтэй барилга байгууламжуудыг дуусгах боломжийг судлах, хөрөнгө оруулалтын бодит хэрэгцээ, үлдсэн ажлуудын санхүүжилтийг оновчтой хуваарилах, хувийн хэвшлийн төлбөрийн чадамжийг хамгаалах чиглэлээр зохицуулалт хийх, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төрийн албан хаагчдын цалин, хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлийг урт болон дунд хугацааны бодлогоор шийдвэрлэх, урсгал зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь тогтоосон хязгаарыг судлан боловсрол, эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг нэмэгдүүлэх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 2024 оны Засгийн газрын санхүүгийн тайланд аудитын байгууллагаас илрүүлсэн зөрчил, алдаа дутагдлын хариуцлагын асуудлыг тодруулж, холбогдох албан тушаалтнуудад ямар арга хэмжээ авсан, мөн аудитын дүгнэлтийн хэрэгжилт, зөвлөмжийн биелэлтийг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл төсвийн шинэчлэлийг хийх шаардлагатайг онцлон, ирэх онд төрийн албан хаагч, ялангуяа багш нарын цалинг нэмэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт нэмж тусгах боломжийн талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд макро эдийн засгийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтээс ахиц гарсан ч урт хугацаанд зөвхөн зэс, нүүрснээс орлого төлөвлөх нь эрсдэлтэй байгааг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

  
Х.ГАНХУЯГ

